



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/127

Улаанбаатар хот

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн  
Бүтээлийн хуулбарлалтыг шалгах  
түр журам батлах тухай


Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, ШУТИС-ийн дүрмийн 4.9.2, 4.14.7, 10.2 дахь заалт, ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Бүтээлийн хуулбарлалтыг шалгах түр журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. “Бүтээлийн хуулбарлалтыг шалгах түр журам”-ыг нийт багш, ажилтанд танилцуулах, мөрдөж хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал (Д.Мягмарсүрэн), Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Д. Цолмонбаатар), бүрэлдэхүүн сургууль, газар, алба, нэгжүүдийн захирал, дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.НАМНАН

367040695



ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн  
2022. оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн  
А/107 дугаар тушаалын хавсралт

	Бүтээлийн хуулбарлалтыг шалгах түр журам ШУТИС-ЭШ-ЖУ04	Эхний хэвлэлт	2022.04.14
		Өөрчилсөн огноо	-
		Өөрчлөлтийн дугаар	0

# Бүтээлийн хуулбарлалтыг шалгах түр журам

## Боловсруулсан:

Ажлын хэсэг

## Хянасан:

Эрдэм шинжилгээ, инноваци, хамтын ажиллагааны дэд зөвлөл

Эрдэм шинжилгээ, инновацийн газар

Чанарын хяналт шинжилгээ, үнэлгээний алба

## Дэмжсэн:

ШУТИС-ийн ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

## Баталсан:

ШУТИС-ийн ЗАХИРАЛ



ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн  
2022 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн  
1127 дугаар тушаалын хавсралт

## АГУУЛГА

АГУУЛГА .....	3
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....	4
ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ .....	4
ГУРАВ. НОРМАТИВ ЭШЛЭЛ .....	4
ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР .....	5
ТАВ. ЭРХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА .....	5
ЗУРГАА. БҮТЭЭЛИЙН ХУУЛБАРЛАЛТЫГ ШАЛГАХ .....	6
ХАВСРАЛТ 1. Бүтээлийн хуулбарлалтыг шалгах үйл явцын зураглал .....	7
ХАВСРАЛТ 2. ХОЛБОГДОХ МАЯГТ .....	8



ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн  
2022 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн  
4137 дугаар тушаалын хавсралт

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Бүтээлийн хуулбарлалтыг шалгах энэхүү журмын зорилго нь судлаачийн ёс зүйг төлөвшүүлэх, зохиогчийн эрхийг хамгаалах, баталгаажуулах, профессор, багш, судлаач, суралцагчдын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлд бүтээлийн хуулбарлалт байгаа эсэхийг шалгах, хуулбарлалтын хувь хэмжээг тогтоохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журмаар Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд ашиглах их сургуулийн профессор, багш, судлаач, суралцагчдын бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, магистрын төгсөлтийн ажил, докторын диссертацийн ажилд бүтээлийн хуулбарлалт байгаа эсэх болон тухайн хуулбарлалтын хувь хэмжээг тогтооно.
- 1.3. Энэхүү журмыг ШУТИС-ийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, захирлын тушаалаар батлуулан мөрдөх ба хэрэгжүүлэх явцад бүтээлийн төрөл нэмэх, бусад нэмэлт өөрчлөлт оруулах саналыг тухай бүр хэлэлцэн шийдвэрлэнэ.

## ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, төв, хүрээлэн, мэргэжлийн салбар, тэнхим, шинжлэх ухаан, технологийн номын сан, магистрын зэрэг хамгаалуулах салбар зөвлөл, профессор, багш, судлаач, суралцагчид хамаарна.

## ГУРАВ. НОРМАТИВ ЭШЛЭЛ

- 3.1. Монгол улсын Дээд боловсролын тухай хууль
- 3.2. Монгол улсын Шинжлэх ухаан, технологийн тухай хууль
- 3.3. Монгол улсын Зохиогчийн эрхийн тухай хууль
- 3.4. ШУТИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрэм
- 3.5. ШУТИС-д магистр, докторын сургалт явуулах, зэрэг хамгаалуулахад баримтлах журам
- 3.6. ШУТИС-ийн профессор, багш нарын ном сурах бичиг, сургалтын материал бичиж, хэвлүүлэхэд баримтлах журам
- 3.7. ШУТИС-ийн Шинжлэх ухаан, технологийн номын сангийн үйл ажиллагааг зохицуулах журам
- 3.8. Төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичиг, хэрэгжүүлэх төлөвлөгөө
- 3.9. ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө
- 3.10. Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэлд хэвлүүлэх эрдэм шинжилгээний өгүүллийн шинэчилсэн загвар



ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн  
2022 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн  
4/27 дугаар тушаалын хавсралт

## ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

- 4.1. **Бүтээлийн хуулбарлалт:** Зохиогчийн эрхийн хамгаалалт бүхий оюуны бүтээлч үйл ажиллагаагаар туурвисан бүтээл, судалгааны тайлан мэдээнээс агуулга, тодорхойлолт болон тоо баримтыг эшлэл, зүүлт хийхгүйгээр хуулбарлах, бусдын бичсэн материалыг өөрийн нэрийн өмнөөс хүлээлгэн өгөх, судалгааны тайлан бүтээлд хуурамч, зохиомол эх сурвалжийг дурдах, бусдын гаргаж дэвшүүлсэн санааг хуулбарлах;
- 4.2. **Бүтээлийн төрөл:** Сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хүрээнд бичигдэж байгаа эрдэм шинжилгээний өгүүлэл, магистрын төгсөлтийн ажил, докторын диссертацийн ажил;
- 4.3. **Бүтээлийн зохиогч:** Сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хүрээнд бичигдэж байгаа эрдэм шинжилгээний өгүүлэл, магистрын төгсөлтийн ажил, докторын диссертацийн ажлыг бичиж туурвисан эрдэмтэн, судлаач, профессор, багш, магистрант, докторант;
- 4.4. **Бүтээлийн хуулбарлалт шалгах:** Бүтээлийн хуулбарлалт шалгах программ хангамжаар бүтээлийн цахим хувилбарыг мэдээллийн санд хадгалагдаж буй бусад бүтээлтэй харьцуулж, агуулгын давхцал байгаа эсэхийг тогтоох;
- 4.5. **Бүтээлийн хуулбарлалтын хувь:** Бүтээлийн төрөл тус бүрээр энэхүү журамд тогтоосон хувиас хэтэрсэн хувь;
- 4.6. **Агуулгын давхцал:** Бүтээлийн агуулга нь өмнө хэвлэгдсэн болон эшлэл авсан бүтээлийн агуулгатай ижил эсвэл хуулбарлагдсан бол.

## ТАВ. ЭРХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 5.1. **Шинжлэх ухаан, технологийн төв номын сан**
  - 5.1.1. Мэдээллийн санг үүсгэж, баяжуулалт хийнэ.
  - 5.1.2. Бүтээлийн хуулбарлалтын программ хангамжийн үйлчилгээ, ашиглалттай холбоотой үйл ажиллагааг хариуцна.
  - 5.1.3. Бүтээлийн хуулбарлалтын бүртгэл мэдээлэл, тайланг гаргана.
- 5.2. **Бүтээлийн зохиогч**
  - 5.2.1. Судлаачийн ёс зүйг эрхэмлэн, зохиогчийн эрхийн зөрчилгүйгээр бүтээлийг туурвина.
  - 5.2.2. Бүтээлийг текст (doc, PDF) хувилбараар мэдээллийн санд оруулж, хуулбарлалтын хувь хэмжээг тогтоох ба журмын 6.3-т заасан шаардлагыг хангасан байна.
  - 5.2.3. Судлаачийн ёс зүйн баталгааг магистр, докторын төгсөлтийн ажилд хавсаргана.
  - 5.2.4. Магистрын төгсөлтийн ажил, докторын диссертацийн ажлын агуулгын давхцалын хувь хэмжээг урьдчилсан хамгаалалтад орохоос өмнө шалгаж, жинхэнэ хамгаалалтад орохдоо баталгаажуулсан байна.
- 5.3. Магистр, докторын судалгааны ажлын удирдагч бүтээлийн хуулбарлалтад тавигдаж буй шаардлагыг хангуулах үүргийг хүлээнэ.



- 5.4. Магистрын төгсөлтийн ажил, докторын диссертацийн ажлын агуулгын давхцалын хувь хэмжээг “Удирдагчийн тодорхойлолт”-д бичиж, магистрын зэрэг хамгаалуулах салбар зөвлөл болон докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд холбогдох материалын хамт танилцуулна.
- 5.5. Эрдэм шинжилгээний өгүүллийн бүтээлийн хуулбарлалтад тавигдаж буй шаардлагыг холбогдох редакцын зөвлөл хангуулах үүргийг хүлээнэ.
- 5.6. Бүтээлийн хуулбарлалттай холбоотой гомдол саналыг сургалт болон эрдэм шинжилгээний асуудал хариуцсан нэгж хянан шийдвэрлэнэ.

### ЗУРГАА. БҮТЭЭЛИЙН ХУУЛБАРЛАЛТЫГ ШАЛГАХ

Бүтээл нь Оюуны өмчийн тухай хууль болон Зохиогчийн эрхийн тухай хуулийг зөрчөөгүй болохыг бүтээлийн хуулбарлалтыг шалгах программ ашиглан баталгаажуулна.

- 6.1. Бүтээлийн хуулбарлалтыг дор дурдсан мэдээллийн сангаас шалгана.
  - 6.1.1. Эрдэм шинжилгээний мэдээллийн сан;
  - 6.1.2. Магистр, докторын судалгааны ажлын мэдээллийн сан;
  - 6.1.3. Олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний мэдээллийн сан;
  - 6.1.4. Мэдээллийн нээлттэй бусад эх үүсвэр.
- 6.2. Бүтээлийн хуулбарлалтын хувь хэмжээг ШУТИС-ийн сургалт, эрдэм шинжилгээний ажлын хүрээнд бичигдэж байгаа эрдэм шинжилгээний өгүүлэл, магистрын төгсөлтийн ажил, докторын диссертацийн ажилд тус тогтооно.
- 6.3. Бүтээлийн төрлөөс хамааран агуулгын давхцалын хувь хэмжээг дараах байдлаар тооцно.
 

6.3.1. Эрдэм шинжилгээний өгүүлэл	40%
6.3.2. Магистрын төгсөлтийн ажил	30%
6.3.3. Докторын диссертацийн ажил	20%
- 6.4. Эрдэм шинжилгээний өгүүллийг хэвлэлтэд өгөхийн өмнө бүтээлийн зохиогч өөрөө агуулгын давхцалыг шалгасан байна.



ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн  
 2022 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн  
 4/127 дугаар тушаалын хавсралт

**ХАВСРАЛТ 1. Бүтээлийн хуулбарлалтыг шалгах үйл явцын зураглал**

ОРОЛЦООНЫ ТАЙЛБАР: **[Responsibility]** - Хариуцан хийж, гүйцэтгэх; **[Accountability]** - Тухайн алхамд хариуцлага хүлээх, батлах; **[Consulted]** - Тухайн алхмыг гүйцэтгэхдээ зөвлөлдөх, хамтрах оролцох; **[Informed]** – Алхмын гаралтыг мэдээлэх

№	Оролт	Үйл явц	Гаралт	Оролцоо /RACI/		
				НС	БЗ	У
1	Тус журам		Мэдээллийн сан	R/A		
2	Мэдээллийн сан		Бүтээлийн төсөл	C	R/A	
3	Мэдээллийн сан Бүтээлийн төсөл		Бүтээлийн хуулбарлалтыг шалгасан үр дүн	C	R/A	C
4	Бүтээлийн хуулбарлалтыг шалгасан үр дүн		Удирдагчийн тодорхойлолт, Ёс зүйн баталгааны хуудас	R/A	C	C/I
5	Бүтээлийн хуулбарлалтын бүртгэл		Бүтээлийн хуулбарлалтын бүртгэл мэдээ, тайлан	A/I		

- \*НС: Шинжлэх ухаан, технологийн төв номын сан
- \*БЗ: Бүтээлийн зохиогч
- \*У: Удирдагч



SHUTIS-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн  
2022 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн  
4/137 дугаар тушаалын хавсралт

## ХАВСРАЛТ 2. ХОЛБОГДОХ МАЯГТ

№	Маягтын нэр	Маягтын дугаар	Хариуцах эзэн /хадгалалт
1	Судлаачийн ёс зүйн баталгаа		

## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

.....  
/Бүрэлдэхүүн сургууль, төвийн нэр/

Хөтөлбөрийн нэр: .....

Хөтөлбөрийн индекс: .....

Суралцагчийн код: .....

## СУДЛААЧИЙН ЁС ЗҮЙН БАТАЛГАА

Магистрант /докторант/ ..... овогтой ..... миний бие энэхүү магистрын төгсөлтийн ажил /докторын диссертацийн ажил/-ыг судлаачийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, оюуны өмчийн зөрчилгүй, бусдын судалгааны ажлаас өөрийн судалгааны ажилдаа эшлэл оруулсан тохиолдол бүрд эх сурвалж, эшлэлийг тодорхой зааж өгсөн ба судалгааны ажлын бичлэгийг стандартын дагуу гүйцэтгэж, бүтээлийн хуулбарлалтын программаар шалган баталгаажуулсан болно.

Энэхүү ёс зүйн баталгаатай зөрчилдөх нөхцөл байдал үүссэн тохиолдолд хариуцлагыг хүлээх болно.

Магистрант /докторант/ .....

/гарын үсэг/

/...../

/нэр/

Баталгаа гаргасан ..... он ..... сар ..... өдөр